



ГОЛОМТ БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03. сарын 07. өдөр

Дугаар 00/03

Улаанбаатар хот

Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.3 дахь хэсэг, Голомт банкны дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.9 дэх заалт, Голомт банкны 2025 оны 03 дүгээр сарын 07-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дугаар сарын 17-ны өдөр зарлаж, өглөөний 09:00 цагт, Шангри-Ла зочид буудлын хурлын их танхимд зохион байгуулсугай.
2. Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1 Голомт Банк ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулга.
 - 2.2 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт.
 - 2.3 2024 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн - Хөндлөнгийн аудитын дүгнэлт.
 - 2.4 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн Тогтоолыг танилцуулах.
 - 2.5 2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан. 2025 оны цалингийн төсөв.
 - 2.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
 - 2.7 Банкны зарласан энгийн хувьцааны тоо ширхэгийг нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийн тухай.
 - 2.8 Хувьцаа эзэмшигч өөрчлөгдхөн тухай.
 - 2.9 Банкны дүрэм өөрчлөн батлах тухай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.4-т заасан шаардлагыг ханган хурал зарласан тухай мэдээллийг олон нийтэд мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг дараах байдлаар тогтоосугай. Үүнд:
 - 5.1 Голомт банкны 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
 - 5.2 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт;
 - 5.3 2024 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн - Хөндлөнгийн аудитын дүгнэлт;
 - 5.4 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн Тогтоол;
 - 5.5 2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан. 2025 оны цалингийн төсөв;
 - 5.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулага;
 - 5.7 Банкны зарласан энгийн хувьцааны тоо ширхэгийг нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийн тухай танилцуулага;
 - 5.8 Хувьцаа эзэмшигч өөрчлөгдхөн тухай танилцуулага;
 - 5.9 Банкны дүрэм өөрчлөн батлах тухай мэдээлэл.
6. Санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолох, үр дүнг гаргах Тооллогын комиссыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг энэхүү тогтоолын Хавсралт №2-ийн дагуу баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдээс санал авах саналын хуудсыг энэхүү тогтоолын Хавсралт №3-ийн дагуу баталсугай.
9. Саналын хуудсаар урьдчилан санал өгөх боломжийг хангаж, саналын хуудсыг урьдчилан хүлээн авах хугацааг 2025 оны 04 сарын 03-ны өдрөөс эхлэн 04 сарын 14-ний өдрийн 12:00 цагаар тасалбар болгосугай.
10. Хурлын даргаар жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл Голомт банкны Ерөнхийлөгч Г.Ганболд-ыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.МОНХЦЭЦЭГ

